



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2026 ОНЫ ЗАХИРАМЖИЙН БИЕЛЭЛТ

(2026 оны эхний хагас жил)

Улаанбаатар хот
2026 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН БИЕЛЭЛТ (2026 оны эхний хагас жил)

2026 оны 06 дугаар сарын 16

Улаанбаатар хот


1.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: “2026 оныг Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарлах тухай, 2026.01.02, А/01

Зүйл, заалтын агуулга: 1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор 2026 оныг "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил" болгон зарласугай.

3.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, үндэсний үйлдвэрлэгч, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, бүтээн байгуулагч зэрэг бизнес эрхлэгчдийг бүх талаар дэмжиж ажиллахыг дүүргийн Засаг дарга, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

Биелэлт:Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилтод жилийн хүрээнд үндэсний үйлдвэрлэгч, жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нар болон аялал жуулчлалын байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах 1 зорилтын 6 арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал:

Гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан “Талын Жавхаа”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр”, “Плэйтийм пре эвент” хөгжмийн наадам, "UB food" олон улсын хоолны фестиваль "Бурхан багшийн дүйчин өдөр", “Талын салхи” олон улсын мото наадам, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль зэрэг 10 арга хэмжээний үеэр 263 жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, үйлчилгээг гаргаж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан.





“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, тур оператор байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран “ITB Berlin”, “ITB China Shanghai”, “Улаанбаатар трaвeл экспo 2026”, “SITF 2026”, “ITE Hongkong” зэрэг 5 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 82 аж ахуй нэгж байгууллагыг хамруулсан.



Аялал жуулчлалын салбар, үндэсний үйлдвэрлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Эдийн засаг хөгжлийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “FEEL MONGOLIA-2026” арга хэмжээг 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгууллаа. “FEEL MONGOLIA-2026” арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэгчид, үйлчилгээний бизнес эрхлэгчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл, эвент арга хэмжээ зохион байгуулагч байгууллагууд, ханган нийлүүлэгчид, зочид буудал, тур оператор зэрэг 150 гаруй аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид оролцон үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.



2.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай, 2026.01.29, А/107

Зүйл, заалтын агуулга: 1. Дотоод, гадаадын иргэд, жуулчдад Монгол Улсын болон Улаанбаатар хотын аяллын талаар хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөө өгөх жуулчны төвүүдийг үргэлжлүүлэн 2026 онд ажиллуулах, нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар (Д.Батсүх)-т даалгасгай.

Биелэлт: Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилготой жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, "Төв шуудан", "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон "Тэрэлж Монгол олле", "Хонхор тосгон Монгол олле", "Сөүлийн гудамж Монгол олле", "Урухан" брэндийн гэр мэдээллийн төв зэрэг нийт 8 байршилд тогтмол болон улирлын чанартай ажиллуулж гадаад, дотоодын нийт 5,749 хүнд, зохион байгуулсан арга хэмжээнүүдийн үеэр жуулчны мэдээлэл сурталчилгааны цэгийг ажиллуулж 3,000 гаруй хүнд буюу нийт 8,749 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Чойжин" жуулчны гэр мэдээллийн төвтэй хамтран ажиллах "Санамж бичиг" байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүлэн нэмэгдүүлж, мөн Жуулчны гудамжинд байрлах "Урт цагаан" үйлчилгээний төвийн нэг давхарт жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.



Ж.СҮХБААТАРЫН ТАЛБАЙ

ЧИНГИС ХААН ОЛОН
УЛСЫН НИСЭХ БУУДАЛХБНГУ-ЫН ФРАЙБУРГ
ХОТЫН ТӨВ

ТӨВ ШУУДАН

"СӨҮЛИЙН ГУДАМЖ
МОНГОЛ ОЛЛЕ""ХОНХОР ТОСГОН МОНГОЛ
ОЛЛЕ"

"ТЭРЭЛЖ МОНГОЛ ОЛЛЕ"

УРУХАН ГЭР
МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

3.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: Ажлын хэсэг байгуулах тухай 2026.03.23, А/403
Зүйл, заалтын агуулга: 1. Нийслэл Улаанбаатар хотын иргэдэд зориулсан соёл, урлаг, спортын болон бусад арга хэмжээг Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 онд зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Биелэлт: Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 онд иргэдэд зориулсан соёл, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтийг харгалзан нэгдсэн хуваарь гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

SUN	MON	TUES	WED	THURS	FRI	SAT
05	06	07	08	09	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	01

SUN	MON	TUES	WED	THURS	FRI	SAT
06	07	08	09	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30	31	01	02

4.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: Ажлын хэсэг байгуулах тухай 2026.04.01, А/462
Зүйл, заалтын агуулга: 1. Монголчуудын өв, соёлыг сурталчлах, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр Хүрээ цам-Даншиг наадам 2026" арга хэмжээг 2026 оны 06 дугаар

сарын 27-28-ны өдрүүдэд Хүй долоон худагт байрлах Монгол наадам цогцолборт зохион байгуулсугай.

Биелэлт: Монголчуудын уламжлалт өв соёлыг таниулан сурталчлах, Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран “Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр-Хүрээ цам даншиг наадам” арга хэмжээг 2026 оны 06 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Хүй долоон худгийн “Монгол наадам цогцолбор”-т зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Ажлын хэсгийн хурлыг нийт 7 удаа зохион байгуулж, арга хэмжээний төсөв, хөтөлбөр, төлөвлөгөөг хэлэлцэн батлуулав.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН БАЯР
“ХҮРЭЭ ЦАМ - ДАНШИГ НААДАМ 2026” НААДАМ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН 4 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ҮҮРЭГ ЧИГЛЭЛ

Иргэдийн баяр “хүрээ цам - даншиг наадам” зохион байгуулах ажлын хэсгийн 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр 4 дүгээр хуралдааны тэмдэглэл.
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН БАЯР “ХҮРЭЭ ЦАМ - ДАНШИГ НААДАМ 2026” арга хэмжээний бэлтгэл ажлын явцтай танилцав.

Энэ асуудалтай холбогдуулан дараах үүрэг чиглэлийг хангах ажиллахыг:			
Д/д	Хариуцах газар	Холбогдох албан тушаалтан нэр	Хариуцах үрэг
1.	Нийслэлийн Засаг Даргын Нийгмийн салбар, Ногоон хөдөө болон Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин	Д.Батсүх	2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах
2.	Улаанбаатар хотын Ерөнхий менежер Бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	Ажлын хэсгийн бүх гишүүд	Төсөвтэй бүх байгууллагууд нэхэмжлэхээ үүсгэж санхүүжилтийн эрхийг нээлтгэх 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор нэхэмжлэхээ үүсгэж санхүүжилтийн асуудлыг тодорхой болгоон байгууллагын удирдлагуудад арга хэмжээ тооцно
3.		Х.Хилигбадрах	Наадам үеэр хүй 7 худгийн талбайд гарах 1. Талбайн усалгааны хуваарь гаргах 2. Морин талбай усалгаанд анхаарах 3. Арга хэмжээний үеэр нийт талбайн усалгаа мэдээллийг танилцуулах 4. Хоол, шингэн, хүнсний худалдаа үйлчилгээг эрхлэх хичнээн байгууллага орох тоо 5. Хэзээнээс талбайд байршиж эхлэх цаг хугацааг нэрифенчэн гаргаж аж ахуй нэгжүүдэд мэдээлэл хүргэх 6. Талбайн хөгжлийг тээвэрлэх, харууцан ажиглах хуваарь гаргах танилцуулах 7. Ил задгай худалдаанд хяналт тавих талаар мэдээлэл бэлтгэн 2026

		2. Талбайн бэлэн байдлыг хангах төлөвлөгөө дараагийн хуралд танилцуулах
13.	Хот тохиоллын газар СНАААТ	Наадам үеэр болон дараа талбайн хөнгө, цэрлэх, тээвэрлэх ажлыг хариуцсан орлогч
14.	СХД, БГД, БЗД, СБД, ЧД, ХУД, НД-ийн Засаг даргын Тамгын газар	Дүүргүүдийн гэрлийн баяр иргэдийг хүлээж авах төвөрсдийн зардлаас гаргах



БАТАЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН САЛБАР, НОГООН ХӨГЖИЛ БОЛОН АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ
А.АМАРТҮВШИН

БОЛОВОРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТСҮХ
ЭВЕНТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Т.БАТДОРЖ

5.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: Арга хэмжээ зохион байгуулах тухай, 2026.04.15, А/570





Зүйл, заалтын агуулга: 1. Улаанбаатар хотод аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх жуулчны улирлын хамаарлыг бууруулах, зорилгоор 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр “Плэйтийм При эвент”, 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд “Улаанбаатар фүүд фестиваль 2026” арга хэмжээг Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

Биелэлт: 1.Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх зорилготой “Плэйтайм-2026” олон улсын хөгжмийн наадмын урьдчилсан “Playtime Pre-Event” арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Лемонс (Lemons), Крайзи сайд ажианс (Crazy sad Asians), Нью борн (Newborn), Стэппу (Starru) зэрэг нийт 5 хамтлаг оролцож, амьд хөгжмийн тоглолтоороо үзэгчдэд уран бүтээлээ хүргэлээ. Мөн Эба дижи (Eba), Ла Бомбэ дижи (La Bombe- DJ) нар орчин үеийн электрон хөгжмийн сет тоглолтыг үзэгчдэд толилуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 3,000 орчим иргэд, залуучууд хүрэлцэн ирж үзэж сонирхов.



2.Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, үндэсний болон олон улсын хоолыг олон нийтэд таниулан сурталчлах, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Улаанбаатар фүүд фестиваль 2026" арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав.

Фестивальд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг "Silk Road", "Asiana", "Bravo", "Dugbe haous", Маханд дуртай мангас, Арт гэр зэрэг 30 ААНБ, Бүгд Найрамдах Азербайжан Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улсаас мэргэжлийн тогооч нар хүрэлцэн ирж оролцсон бөгөөд нийт 18 улсын үндэстний хоолоор үйлчилсэн. Арга хэмжээний өдрүүдэд "Улаанбаатар театр"-ын уран бүтээлчдийн тоглолт, амьд хөгжмийн тоглолт, хамтлаг, дуучид, уран бүтээлчдийн тоглолт болон DJ үзүүлбэр, Open Mic, Magic Mascot, хоолны шоу үзүүлбэр, үзэгчдийн дунд хөгжөөнт тэмцээн уралдаануудыг зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 108,000 гаруй иргэд жуулчид үзэж сонирхсон.





6.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: “Бурхан багшийн Их дүйчин” өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах тухай, 2026.05.22, А/767

Зүйл, заалтын агуулга: 1. Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор “Бурхан багшийн их дүйчин өдөр” шашин соёлын арга хэмжээг “Жанжин Д.Сүхбаатарын талбайд” 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсугай.

Биелэлт: Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор Монголын бурхан шашинтны төв-Гандантэгчэнлин хийдтэй хамтран “Бурхан багшийн их дүйчин өдөр” шашин, соёлын арга хэмжээг “Амар амгаланг хамтдаа түгээе” уриан дор жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Бурхан багшийн их дүйчин өдрийн гэрэлт жагсаалд Хотол чуулганд амар мөр ТББ, Тэжээхүйн ухаан ТББ,

Наробанчин төв, Гандантэгчинлэн хийд, Дилав худагт сан, Өндөр гэгээн занбазарын нэрэмжит Монголын бурхан шашны дээд сургууль зэрэг байгууллагуудын 1000 гаруй хүн оролцлоо. Арга хэмжээний үеэр урлаг соёлын тоглолт, хөгжимт бясалгал, випашяна бясалгал зэрэг соёлын арга хэмжээг зохион байгуулж нийт 5000 гаруй гадаад, дотоодын иргэд жуулчид, сүсэгтэн олон үзэж сонирхсон.




7.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: “Тэнгэр” олон улсын наадам зохион байгуулах тухай, 2026.05.26, А/803

Зүйл, заалтын агуулга: 1. Монгол уламжлалт ёс заншлын салшгүй чухал соёлын өв болох тэнгэр, газар шүтлэгийн зан заншлыг тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор “Тэнгэр” олон улсын наадмыг “Чингис Хааны Хүрээ” цогцолборт 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 06 дугаар сарын 14-ний өдрүүдэд зохион байгуулахыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар (Д.Батсүх)-т даалгасугай.

Биелэлт: Монголын уламжлалт ёс заншлын салшгүй чухал соёлын өв болох тэнгэр, газар шүтлэгийн зан заншлыг тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор “Тэнгэр тайлал” НҮТББ-тай хамтран “Тэнгэр” олон улсын наадмыг 2026 оны 6 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт 3 дахь жилдээ зохион байгууллаа. Наадамд Канад Улс, Япон Улс, АНУ, БНХАУ, БНСУ, ОХУ, ББНВУ, БНФУ, БНПУ, Англи Улс зэрэг 33 улс орноос 256 бөө, Монгол Улсаас 15 бөөгийн холбооны 100 гаруй бөө оролцов.

Арга хэмжээний үеэр дэлхийн олон улсын бөөгийн эрдэм шинжилгээний хурал, нарны залбирал, бөөгийн туг сүлд залах ёслол, галын болон лусын тахилга зэрэг бөө мөргөлийн ёс заншлыг үзүүллээ. Арга хэмжээний үеэр үзэгч, оролцогч гадаад, дотоодын бөө нарт зориулан урлагийн тоглолт, морьтон баатруудын үзүүлбэр, морин уралдаан болон орон

орны бөөгийн өв соёлтой танилцан отгуудаар зочлох, морь унах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 20,000 гаруй иргэд жуулчид үзэж сонирхсон.





8.Шийдвэрийн нэр, огноо, дугаар: “Талын салхи-2026” олон улсын мото наадам зохион байгуулах тухай, 2026.05.26, А/804

Зүйл, заалтын агуулга: 1. Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Талын салхи-2026” олон улсын мото наадмыг 2026 оны 06 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулахыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар (Д.Батсүх)-т үүрэг болгосугай.

Биелэлт: Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох зорилгоор Монголын чопперчин ахан дүүс ТББ-тай хамтран “Талын

салхи-2026" олон улсын мото наадмыг "Эх хүүхдийн эрүүл мэндийн төлөө" уриан дор 11 дэх жилдээ 2026 оны 06 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбай болон "Говь ресорт"-д зохион байгууллаа. Мото фестивалд оролцогчид Энхтайваны өргөн чөлөө буюу Д.Сүхбаатарын талбай- Улсын их дэлгүүр- Баруун дөрвөн зам- Таван шар- 22-ын товчоо- Говь ресорт" гэсэн маршрутаар 43 км мото парад зохион байгуулж, арга хэмжээнд БНХАУ, ОХУ, БНСУ, Унгар зэрэг улсуудаас 200 гаруй хүн, Монгол Улсаас Улаанбаатар хот болон 21 аймгийн 70 клубийн 3800 гаруй нийт 4000 гаруй мотоцикл сонирхогчид оролцов. Арга хэмжээний үеэр оролцогчдын дунд гар барилдах, туг сүлжих, мото удаан явах зэрэг тэмцээн уралдаан болон мото түүний дагалдах хэрэгслийн үзэсгэлэн, гэр, майхан кемпийн үйлчилгээ, хоол, ундааны үйлчилгээ болон мото үзүүлбэр, урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ГАНБОЛД

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ